



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/78

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Баянцагаан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

С.Аюурзана (Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГ газрын инженер)

Б.Энхсайхан (Баянцагаан сумын Засаг даргын орлогч)

Д.Дашдаваа (Иргэний төлөөлөл (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа (Төв аймгийн Орон нутгийн газрын худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Ганхуяг)-д, ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122010246